



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот

Өөрийгөө зохицуулах байгууллагыг
бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх журам”-ын 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэсүгэй.

2. Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэсэнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, биелэлтийг эргэн тайлагнахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор /-д үүрэг болгосугай:

1/ Хууль тогтоомжоор тавигдаж буй шаардлагыг хангах чиглэлээр нэг жилийн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, мөрдөж ажиллах;

2/ Хуулийн этгээдийн бүртгэлд зохих өөрчлөлтийг бүртгүүлэх.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001016